



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2009 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 271

Улаанбаатар хот

“Урт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Урт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ журмыг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны “Урт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”батлах тухай 65 дугаар тогтоолыг энэ тогтоолын 1-д заасан журам үйлчилж эхэлмэгц хүчингүй болсонд тооцсугай.

4.Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Даатгалын тухай хуулийн 14.2.2 дахь зүйлийг хэрэгжүүлэх, урт хугацааны даатгалын төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Урт хугацааны даатгалын компани (цаашид “даатгагч” гэх) нь даатгуулагчийн өмнө хүлээсэн хариуцлагаа бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй байвал зохино.

1.3.Дор дурдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно:

1.3.1.“Хувь оролцоотой (participating) гэрээ” гэж гэрээний үргэлжлэх хугацаанд даатгуулагч нь даатгалын компанийн ашгаас ноогдол ашиг авах нөхцөл бүхий урт хугацааны даатгалын гэрээг;

1.3.2.“Хувь оролцоогүй (non participating) гэрээ” гэж гэрээний үргэлжлэх хугацаанд даатгуулагч нь даатгалын компанийн ашгаас ноогдол ашиг авах талаар гэрээнд заагаагүй урт хугацааны даатгалын гэрээг;

1.3.3.“Хөрөнгө оруулалттай холбоотой (investment linked) гэрээ” гэж даатгалын хураамжийн зохих хэсэг нь даатгуулагчийн хүсэл сонирхол болон тодорхой гэрээнд заасан нөхцлийн дагуу хөрөнгө оруулалтад байршдаг урт хугацааны даатгалын гэрээг;

1.3.4.”Даатгалын гэрээний эрсдэлтэй хэсэг” (sum insured at risk) гэж даатгагчийн байгуулсан даатгалын гэрээний нөөц санд тооцогдоогүй үлдсэн бусад хэсгийг;

1.3.5.“Өр төлбөр” гэж даатгагчийн санхүүгийн тайлангийн Өр төлбөр хэсэгт тусгагдсаныг.

1.4.Даатгагчийн төлбөрийн чадварыг тооцоход баталгаажсан санхүүгийн тайлан, тэнцлийн үзүүлэлтүүдийг ашиглана.

ХОЁР.Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт

2.1.Даатгагчийн төлбөрийн чадварын байдлыг тодорхойлохдоо төлбөрийн чадварын зохистой харьцаа, төлбөрийн чадварын хязгаар гэсэн 2 үзүүлэлтээр тооцно.

2.2.“Төлбөрийн чадварын зохистой харьцаа”-г тооцохдоо даатгагчийн зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнг өр төлбөрийн дүнд харьцуулж хувиар илэрхийлж тогтооно. (Төлбөрийн чадварын зохистой харьцаа =(Зөвшөөрөгдөх хөрөнгийн дүн/ Өр төлбөрийн дүн)*100%)

2.2.1.Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 125 хувь буюу түүнээс дээш байна.

2.2.2.Хэрэв даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа 100-125 хувийн хооронд байвал даатгагчийг төлбөрийн чадваргүй болж болзошгүйд тооцно.

2.2.3.Хэрэв даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа 100 хувиас доош байвал даатгагчийг төлбөрийн чадваргүй болсонд тооцно.

2.3.“Төлбөрийн чадварын хязгаар”-ыг тооцохдоо даатгагчийн зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнгээс өр төлбөрийн дүнг хасч тогтооно. (Төлбөрийн чадварын хязгаар = Зөвшөөрөгдөх хөрөнгийн дүн - Өр төлбөрийн дүн)

2.4.Даатгагчийн төлбөрийн чадварын хязгаар нь даатгагчийн төлбөрийн чадварын хамгийн бага үзүүлэлттэй тэнцүү буюу түүнээс дээш байна.

2.5.Хэрэв даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа болон төлбөрийн чадварын хязгаарын аль нэг нь шаардлага хангаагүй бол тухайн даатгагчийг төлбөрийн чадваргүй болсонд тооцно.

2.6.Төлбөрийн чадварын хамгийн бага үзүүлэлт нь нөөцийн сангийн актуар тооцооллын хувь (2.6.1) ба даатгалын гэрээний эрсдэлтэй хэсгийн үнэлгээний хувь (2.6.2)-ийн нийлбэртэй тэнцүү байх бөгөөд хэрэв энэ нийлбэр нь зайлшгүй байх хөрөнгийн хэмжээ (2.6.3)-нд хүрэхгүй тохиолдолд зайлшгүй байх хөрөнгийн хэмжээ (2.6.3)-гээр тооцож байна. Үүнд:

2.6.1.Нөөц сангийн актуар тооцооллын хувь (хувь оролцоогүй гэрээний нөөц сангийн 3 хувь болон хувь оролцоотой гэрээний нөөц сангийн 2 хувь, хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сангийн 1 хувиар тооцсоны нийлбэр байна. Өмнөх санхүүгийн жилийн эцсийн байдлаар тооцно);

2.6.2.Даатгалын гэрээний эрсдэлтэй хэсгийн үнэлгээний хувь (өмнөх санхүүгийн жилийн төгсгөл дэх нийт даатгалын гэрээний эрсдэлтэй хэсгийн үнэлгээний 0.2 хувиар тооцно. Энэ нь давхар даатгалд шилжүүлсэн гэрээг хасаж тооцно);

2.6.3.Зайлшгүй байх хөрөнгийн хэмжээ нь Хорооноос тогтоосон даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээгээр тооцно.

ГУРАВ. Зөвшөөрөгдөх хөрөнгө

3.1.Даатгагчийн зөвшөөрөгдөх хөрөнгө нь компанийн нийт хөрөнгийн дүнгээс зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг хассанаар тодорхойлогдоно.

3.2.Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө гэж даатгалын компанийн төлбөрийн чадварын үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж болохуйц хөрөнгийг хэлнэ. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийг тухайн хөрөнгийн дүнгээс дараах хувиар тооцно:

3.2.1.Банкны харилцах, хадгаламж	0%
3.2.2.Касс	0%
3.2.3.Засгийн газрын бонд	0%
3.2.4.Орон нутгийн засаг захиргааны бонд	10%
3.2.5.Компанийн бонд	10%
3.2.6.Төв банкны үнэт цаас	0%
3.2.7.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	8%
3.2.8.Банкны хадгаламжийн сертификат	0%
3.2.9.Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг	5%

3.2.10. Хөрөнгө оруулалтын сан /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй, эсхүл хаалттай санг ойлгоно./	20%	Нээлттэй сан: 5%
		Хаалттай сан: 10%

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 276 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

3.2.11. Үл хөдлөх хөрөнгө 8%

3.2.12. Давхар даатгалын авлага 0%

3.2.13.90 хоногоос доош хугацаанд төлөгдөөгүй байгаа авлага 0%

3.2.14. Бусад авлага 100%

3.2.15. Биет бус хөрөнгө 100%

3.2.16. Бараа, материал, тоног төхөөрөмж 100%

3.2.17. Урьдчилж төлсөн зардал 100%

3.2.17 ¹ . МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа	I ангилал	10%	20%
	II ангилал	5%	30%

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 276 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

3.2.17 ² . Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	20%	5%
---	-----	----

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 276 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

3.2.18. Бусад хөрөнгө (даатгагчийн хөрөнгийн 3.2.1-3.2.17-д зааснаас бусад хөрөнгө) 100 %

ДӨРӨВ. Хяналт тавих

4.1. Даатгагч нь сар бүр, шаардлагатай гэж үзвэл тухайн бүрд төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцож байх бөгөөд хэрэв төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 3 хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй.

4.2. Даатгагч төлбөрийн чадварын тайланг энэ журмын хавсралтын дагуу гарган санхүүгийн тайлангийн хамт улирал бүр Хороонд ирүүлнэ.

4.3. Даатгагч нь төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд Хороо нь Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэн шаардлагатай арга хэмжээг авна.

“Урт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур
үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын хавсралт

/Энэ хавсралтад Санхүүгийн зохицуулах хорооны
2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 499
дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан./

/мянган төгрөгөөр/

1. Төлбөрийн чадварын хамгийн бага үзүүлэлт / $I = \max(a) + (b); (c)$			
Зүйл	Дүн	Тооцох хувь	Нийт дүн
(a) Нөөцийн сангийн актуар тооцоолол			
Хувь оролцоогүй гэрээний нөөцийн сангийн		3%	0.0
Хувь оролцоотой гэрээний нөөцийн сангийн		2%	0.0
Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөцийн сан		1%	
(b) Эрсдэлд байгаа даатгалын гэрээний үнэлгээ			
Өмнөх санхүүгийн жилийн төгсгөл дэх нийт эрсдэлд байгаа даатгалын гэрээний үнэлгээний		0.2%	0.0
(c) Зайлшгүй байх хөрөнгө /дүрмийн сангийн доод хэмжээ/			
2. Нийт хөрөнгө			
	Дүн	Бууруулах хувь	Тохиргоо хийгдсэн дүн
3. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө			
Банкны харилцах, хадгаламж		0%	
Касс		0%	
Засгийн газрын бонд		0%	
Орон нутгийн засаг захиргааны бонд		10%	
Компанийн бонд		10%	
Төв банкны үнэт цаас		0%	
Монголын хөрөнгийн биржид арилжаалагдсан үнэт цаас		10%	
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас		8%	
Банкны хадгаламжийн сертификат		0%	
Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг		5%	
Хөрөнгө оруулалтын сан /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй, эсхүл хаалттай санг ойлгоно. <i>/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 276 дугаар тогтоолоор өөрчилсөн/</i>		Нээлттэй сан: 5% Хаалттай сан: 10%	
Үл хөдлөх хөрөнгө		8%	
Давхар даатгалын авлага		0%	
90 хоногоос доош хугацаанд төлөгдөөгүй байгаа авлага		0%	
Зөвшөөрөгдсөн хөрөнгөөр барьцаалсан зээл		10%	
МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа <i>/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 276 дугаар тогтоолоор өөрчилсөн/</i>	I ангилал	20%	
	II ангилал	30%	
Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө <i>/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 276 дугаар тогтоолоор өөрчилсөн/</i>		5%	
Бусад авлага		100%	
Биет бус хөрөнгө		100%	
Бараа материал, inventory, тоног төхөөрөмж		100%	
Урьдчилж төлсөн зардал		100%	
Бусад хөрөнгө		100%	
4. Зөвшөөрөгдөх хөрөнгө / $4 = (2) - (3)$			

5. Өр төлбөр / 5=урт хугацаат өр төлбөр+богино хугацаат өр төлбөр/			
6. Төлбөрийн чадварын зохистой харьцаа / $6=(4)/(5) \geq 125\%$			
7. Төлбөрийн чадварын хязгаар / $7=(4)-(5) \geq (1)$ /			